



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын
сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Аудитор: У.Энхчимэг Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
1.1Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12



Аудитын гэрчилгээ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 240

танай _____-ны № _____-т

МАТАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ГОЁЛМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Матад сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Матад сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Матад сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

110520073



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд хийгдсэн бараа материалын гүйлгээний анхан шатны баримтууд нь бүрдэл дутуу, бараа материалыг тайланд "материал", "хүнс", "багц 1 багц 2 багц 3" гэх мэт тодорхойгүй нэрээр бүртгэсэн, харилцах дансаар 19.5 сая төгрөгийн нэхэмжлэхгүй гүйлгээ хийсэн, бараа материал нийлүүлсэн харилцагчидтай гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн тэмдэглэл байхгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэрэг нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 13.7 дахь хэсэгт заасан "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4 дэх хэсэгт заасан "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн бодитой ба тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Гоёлмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нээс 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар “Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль” -ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль” -ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Дундаас сайнд, Сайн багш, Сайн албан хаагч, Сайн сурагч, Сайн сургууль болоход оршино.

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль” -ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Aхplorer программ хангамж ашигладаг байна.

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 536,118.9 мянган төгрөгөөс тооцон 10,722.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,722.3 мянган төгрөгөөр тооцсон нь төсвийн байгууллагын хувьд зардал гол үзүүлэлт байдагтай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Матад сумын ерөнхий боловсролын сургууль”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,478.90 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	156.00	-	(156.00)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,420.10	80,849.40	7,429.30
Үндсэн хөрөнгө	1,052,338.56	1,055,646.69	3,308.13
Хуримтлагдсан элэгдэл	(155,674.31)	(180,734.61)	(25,060.30)
Нийт хөрөнгө	970,240.40	955,761.50	(14,478.90)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	545,519.40	531,040.50	(14,478.90)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	970,240.40	955,761.50	(14,478.90)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага буурснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь худалдан авсан болон хандивын бараа материалыг бүртгэж авснаас шалтгаалжээ. Бараа материалын



дансны үлдэгдэлд 47,587.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна. 2020 онд залруулж бүртгэх шаардлагатай.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 38,879.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 35,571.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 531,040.50 мянган төгрөг болж 14,478.90 мянган буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 474,065.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 431,424.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 42,639.7 мянган төгрөгийг Үдийн цай, дотуур байрны зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 450,365.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,700.0 мянган төгрөг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466,635.6 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь түлш халаалт, цахилгаан эрчим хүчний зардалтай хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дорнод аймгийн Боловсрол соёл урлагийн газраас багш нарын сургалтад зориулж 1,500.0 мянган орлогыг бүрдүүлжээ.

Тус орлогыг зориулалтын дагуу багш нарын сургалтанд 100% зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 199,019.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 95,780.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 103,238.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 151,432.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 1-р гарын үсэггүй, байгууллагын тамгагүй гүйлгээг төрийн сангаар хийсэн байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 13.5-д заасан "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр



бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

2. Бараа материалын тайлангаас анхан шатны баримтаар тулгалт хийхэд 1 дүгээр гарын үсэг, 2-р гарын үсэг зурж тамга дарсан боловч ямар ч гүйлгээний утгагүй хоосон шаардахын баримт хавсаргасан, жолоочийн тооцооны хуудас хоосон, бараа материалын тайланд орлогод авахдаа материал, хангамжийн материал, багц1, багц2, багц3 гэх мэтээр тодорхойгүй нэрээр орлогод авсан зэрэг нь бараа материалын орлого, зардлыг бодитой хийгдсэн гэж үзэх боломжгүй байна. Мөн анхан шатны баримтууд хоорондоо зөрүүтэй бүртгэгдсэн байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13.7-д заасан “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20.1.4-д заасан “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалттай нийцэхгүй, бодитой ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

3. Харилцагч бүртэй гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулсан тэмдэглэл үйлдээгүй, тооцоо нийлсэн акт огт үйлдээгүй байгаа нь тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

4. 2019 онд 75,434,716.00 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч эдгээрээс 19,783,357.00 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нь Е-баримттай байна. 55,651,359 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

5. Бараа материалын тайлангаас анхан шатны баримтаар тулгалт хийхэд 1 дүгээр гарын үсэг, 2-р гарын үсэг зурж тамга дарсан боловч ямар ч гүйлгээний утгагүй хоосон шаардахын баримт хавсаргасан, жолоочийн тооцооны хуудас хоосон, бараа материалын тайланд орлогод авахдаа материал, хангамжийн материал, хүнс, багц1, багц2, багц3 гэх мэтээр тодорхойгүй нэрээр орлогод авсан зэрэг нь бараа материалын орлого, зардлыг бодитой хийгдсэн гэж үзэх боломжгүй байна. Энэ нь



“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13.7 дахь хэсэгт заасан “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20.1.4 дэх хэсэгт заасан хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалт, бодитой ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 47,587.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Матад сумын ерөнхий боловсролын сургууль” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 41 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 17,066.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “*Матад сумын ерөнхий боловсролын сургууль*”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

“*Матад сумын ерөнхий боловсролын сургууль*”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 75,434,716.00 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Хүнсний материал худалдан авах тендер зарласан боловч тендер нээсэн тэмдэглэл байхгүй, тендерийг яаж шийдвэрлэсэн тухай тэмдэглэл байхгүй байна. Шууд худалдан авалт хийсэн компани, хувь хүмүүстэй жилийн эцэст тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө болон тайлан байхгүй.

1.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаа төлөвлөлтгүй хийгдэж байгаа нь төсвийн хөрөнгөөр үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлнэ.



2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгөд бүртгэх . 31,400,457.00 төгрөгийн тавилга эд хогшил, 16,186,838.20 төгрөгийн үнэтэй номыг бүртгэсэн байна.

2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй нь тайлант хугацааны элэгдлийн зардал дутуу тооцоологдох эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17 болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын НБББББ-ыг мөрдөж ажиллах. Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг зөв бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Матад сумын ИТХ-аар тогтоол гаргуулж үндсэн хөрөнгийн дансандаа бүртгэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.